*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# НИЙГМИЙН ДААТГАЛ, ХУРИМТЛАЛЫН САНГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН ХЭЛТСИЙН ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ Ж.ЦОГЗОЛМААГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн хүрээнд Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний талаар холбогдох шийдвэрийг гаргах; | Засгийн газрын тогтоол | Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд 507.1 тэрбум төгрөг, хүүгийн орлогоор 55.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр баталсан. | 1 | Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562.1 тэрбум төгрөг байхаар хуульчилсан. Энэхүү эх үүсвэрийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийг санхүүжүүлэх хэлбэрээр санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулж, арвижуулах, арга хэмжээ авах агуулга бүхий Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар | 2025.01.01-2025.06.30 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлэлцүүлэн “Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 228 дугаар тогтоолыг батлуулсан | | |
| 2. | Арга хэмжээ 1.2.Хуримтлалын сангийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; | Төсвийн төсөл | Хуримтлалын сангийн 2024 оны төсвийн төслийг боловсруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. | 1 | Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562.1 тэрбум төгрөгөөр баталсан. Хуримтлалын сангийн 2026 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн цаглаврын дагуу хүргүүлэхтэй холбоотой орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд Эрдэнэс Монгол ХХК-аас 2026 оны орлогын төсөөллийг ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн. 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэлд Хуримтлалын сангийн 2026 оны орлогын төлөвлөгөөг 435.5 тэрбум төгрөг, хүүгийн орлого 149.7 тэрбум төгрөг байхаар тооцон санал боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн. | 2025.01.01-2025.06.30 | 100% |
| 3. | Арга хэмжээ 1.3.Хуримтлалын сангийн сангийн үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гаргаж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны | Тайлан | Хуримтлалын сангийн 2024 оны үйл ажиллагааны тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн | 1 | Хуримтлалын сангийн 2024 үйл ажиллагааны тайланг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1318 тоот албан бичгээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. Хуримтлалын сангийн 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны тайланг санхүү, | 2025.01.01-2025.06.30 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төв байгууллагад хүргүүлэх; | | захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. | | төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр бэлдэж байна. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4.Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашиг болон бусад нэмэлт орлогоо Хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулахаар хүсэлт гаргасан иргэдийн мөнгөн хөрөнгийг Хуримтлалын сангийн дансанд шилжүүлэхтэй холбогдох шийдвэрийг гаргах; | Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл | Өөрийн хүсэлтээр хуримтлалын нэрийн дансанд орлого бүртгэж байгаагүй. | 3 | Монгол Улсын Засгийн газраас Хуримтлалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 9, 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашгаа хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулах эсэх талаар "И-Монголиа" цахим системээр дамжуулан иргэдээс баталгаажуулах санал асуулгыг явуулахад 600 иргэн ногдол ашгаа хуримтлуулах санал өгсөн болно.<br><br>"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашгийг Хуримтлалын сангийн хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулах саналыг "И-Монголиа" цахим системээр дамжуулан гаргасан иргэдийн ногдол ашгийг Монголбанкан дах Төрийн сангийн Үндэсний баялгийн сан (Хуримтлалын сан) шилжүүлэх зохицуулалтыг тусгасан "Хуримтлалын сангийн талаар | 2025.01.01-2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/874 тоот албан бичгээр яамдаас санал авч, Засгийн газрын, 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 177 дугаар тогтоолоор батлуулсан. Иргэн өөрийн хүсэлтээр хуримтлалын нэрийн дансанд оруулсан 2024 оны “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааны ногдол ашгийн орлогыг төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системийн Профайл цэсийн "Чингис Хаан" Үндэсний Баялгийн сан хэсгээс Хуримтлалын нэрийн дансны мэдээллээс шалгах боломж бүрдүүлсэн. | | |
| 5. | Арга хэмжээ 1.5.Хуримтлалын сангийн талаарх олон улсын туршлага, хууль эрх зүйн орчин, холбогдох тайлан, мэдээ, дүн шинжилгээ, үндэсний болон олон улсын байгууллагын судалгаа, статистик, тоон мэдээллийг судлах, санал боловсруулах; | Тайлан | Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцжуулалттай уялдуулан хэрэгжүүлэх чиглэлээр орон сууцны бодлого тодорхойлогч талуудтай хамтран ажиллаж "Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог | 1 | Монгол Улсын Ерөнхий Сайдын УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хийсэн Үндэсний баялгийн сангийн хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэлд олон улсын туршлагын талаар дараах мэдээллийг бэлтгэн танилцуулсан. Үүнд: Сүүлийн жилүүдэд баялгийн сангуудын удирдаж буй хөрөнгийн хэмжээ тогтвортой өсч өдгөө дэлхий дахинд 100 гаруй сан нийтдээ 13 их наяд ам.долларын хөрөнгө удирдаж байна. Энэ нь дэлхийн ДНБ-ний бараг 10 орчим хувийг | 2025.01.01-2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжүүлэх арга хэмжээний санал" боловсруулах чиглэлээр ажиллаж байна. Мөн олон улсын туршлагыг судлан ажиллаж байна. | | хамарч байгаа нь тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөө асар их болсныг илтгэнэ.<br>Баялгийн сангуудын хөрөнгийн эх үүсвэр нь улс орны онцлог болон эдийн засгийн бүтэцтэй уялддаг. Жишээлбэл, газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын экспортын орлогод суурилсан баялгийн сангуудын дунд Норвегийн "Government Pension Fund Global" (GPFG), Абу Дабигийн "Abu Dhabi Investment Authority" (ADIA), Кувейтын "Kuwait Investment Authority" (KIA), Катарын "Qatar Investment Authority" (QIA) зэрэг нэр хүндтэй сангууд багтдаг. Эдгээр нь үндсэндээ байгалийн нөөцөөс бий болсон орлогыг ирээдүйн хэрэгцээнд зориулан хуримтлуулж, эрсдэл багатай, өгөөж өндөртэй байдлаар олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг.<br>Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний тогтолцоог сайжруулах, орон сууцны хөнгөлөлттэй ипотекийн зээлийг зорилтот бүлэг рүү чиглүүлэх, орон сууцны тухай хууль эрх зүйн орчны сайжруулах хүрээнд ҮБСОСҮХ-ны ажлын албатай хамтран ажиллаж, дараах уулзалт, арга хэмжээнд оролцоог хангасан. Үүнд:<br>- 2025.01.07-ны өдөр УБ 2040 хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг танилцуулах, мэдээлэл солилцох үүднээс хот байгуулалт, орон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сууцжуулалтын салбарын холбогдох ажилтнуудтай зөвлөлдөх уулзалт<br>- Дэлхийн банкны төлөөлөгчидтэй 2025 оны эхний улиралд нийт 3 удаа уулзалт зохион байгуулан орон сууцжуулах стратегийн замын зураглалын төслийг боловсруулах техникийн туслалцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цаашид хамтран ажиллах талаарх уулзалт<br>- Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч болон Улаанбаатар хотын ногоон орон сууцны төслийн мэргэжилтнүүдтэй 01 дүгээр сарын 30-ны өдөр зөвлөлдөх уулзалтын хүрээнд нийслэлийн гэр хороолол, дэд төвүүдэд АХБ-наас хэрэгжүүлж буй төслийн хэрэгжлитийн талаарх мэдээлэлтэй танилцсан.<br>- Tony blair institute-ийн орон сууцны салбарын эксперттэй 02 дугаар сарын 03-нд ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн зээлийн хэрэгжилт, алдаа, ононы талаар мэдээлэл солилцож тухайн байгууллагаас гаргаж буй саналтай танилцсан.<br>- Бүгд Найрамдах Казахстан улсын Орон сууцны хувьцаат компанитай орон сууцны бодлого, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, эрэлтийг дэмжих, урт хугацааны стратегийн замын зураглалын талаар мэдлэг, туршлага судалсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Иргэдийг орон сууцжуулах бодлогыг сайжруулах, ипотекийн зээлийн журмыг шинэчлэх саналыг Монголбанк, ХББОСЯ, НЗДТГ, ШСБХ төв, ҮБСОСҮХ-ны ажлын алба хамтран боловсруулж, Ерөнхий сайдад 2025.03.20-ны өдөр танилцуулсан. | | |
| 6. | Арга хэмжээ 1.6.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Хуримтлалын санг орон сууцны санхүүжилттэй урт хугацаанд уялдуулах ажлын хүрээнд орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах зорилтот бүлгийг тодорхойлсон судалгаа хийнэ. | Боловсруулсан тооцоо, судалгааны тоо | Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах, хуримтлалын сангийн эх үүсвэрээр хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээлд хамрагдах зорилтот бүлгийг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, холбогдох байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийсэн. | 1 | Монгол Улсын Засгийн газар, Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны орон сууцны урт хугацааны бодлого тодорхойлох, ипотекийн зээлийн эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх, урт хугацаанд хэрэгжүүлэх санхүүжилтийн загварыг тодорхойлох зорилтын хүрээнд орон сууцны бодлого тодорхойлогчид болон банк санхүүгийн байгууллагын төлөөлөл хамтран ажиллаж "Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх арга хэмжээний санал" боловсруулах чиглэлээр ажиллаж байна. Ипотекийн зээлийн бүтээгдэхүүнд нэн тэргүүнд хамрагдах орон сууцгүй, 1 ба түүнээс дээш хүүхэдтэй, ажил эрхэлдэг, өрхийн сарын орлого нь 1-2 сая төгрөг хүртэл, 40 ба түүнээс доош насны өрхийн тэргүүлэгчтэй зорилтот 17,292 өрхийн мэдээллийг боловсруулан үүнээс дахин төлөвлөлт, нийслэлийн төсөл, дэд төвийн бүсүүдэд амьдарч 4,092 өрхийн мэдээллийг гаргаж Үндэсний баялгийн сан, | 2025.01.01-2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орон сууцжуулалтын үндэсний хороонд хүргүүлсэн. Зорилтот бүлгийг тодорхойлох судалгааны хүрээнд анх удаа орон сууц авч буй залуу болон олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлийг тус тус орлогын түвшин, байршлаар тодорхойлсон болно.<br>Бүгд Найрамдах Казахстан Улсын орон сууцны хөнгөлөлттэй зээл болон хадгаламжийн талаар мэдээлэл, судалгаа боловсруулсан. Бүгд Найрамдах Казахстан Улс зорилтот бүлгийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:<br>-олон хүүхэдтэй гэр бүл<br>-хөгжлийн бэрхшээлтэй иргэн<br>-хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өсгөж буй гэр бүл<br>-өнчин, эцэг эхийн хараа хяналтгүй үлдсэн хүүхдүүд<br>-залуу гэр бүл<br>-анх орон сууц авч байгаа иргэн<br>-ажилтны орон сууцны хөнгөлөлттэй зээл<br>-бага орлоготой өрх зэрэг болно. | | |
| **Зорилт 2. “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 3 | гишүүн Г.Лувсанжамцаас “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 93 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар ирүүлсэн асуулгын хариуг | 2025.01.01-2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангах зорилгоор иргэд, олон нийтэд сурталчлан таниулна. | | | | 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01/606 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>-2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хуримтлалын сангийн үйл ажиллагааны талаар иргэдэд зориулсан постер мэдээлэл бэлтгэсэн.<br>-Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга А.Хишигбаяр “Нээлттэй нийгэм форум” өдөрлөгт 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Хуримтлалын сангийн талаар мэдээлэл танилцуулсан. | | |
| 2. | Арга хэмжээ 2.2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана. | Хамтран ажилласан байгууллагын тоо | Улсын бүртгэлийн ерөнхий газар, И-Монгол академи, Үндэсний дата төв, Санхүүгийн мэдээллийн технологийн төв, Монголбанк, Эрдэнэс Монгол ХХК болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. | 2 | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж байна. Үүнд:<br>Бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд: ЗГХЭГ, Сангийн яам, Монголбанк, Эрдэнэс Монгол ХХК, Чингис Хаан Үндэсний баялгийн сан ХХК, Хуримтлалын сангийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд: Улсын бүртгэлийн ерөнхий газар, И-Монгол академи, Үндэсний дата төв, Санхүүгийн мэдээллийн технологийн төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Эрдэнэс Таван толгой ХК,<br>Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны хөнгөлөлттэй зээлийн | 2025.01.01-2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжилт, тогтолцооны шинэчлэлтийг эхлүүлэх чиглэлээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо, хорооны ажлын алба, Эдийн засгийн хөгжлийн зөвлөл зэрэг байгууллагатай хамтран ажиллаж байна. - Ипотекийн зээлийн хэрэгжилт, иргэдийн орлоготой уялдуулах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол банк, ХББОСЯ, Эдийн засаг хөгжлийн төвтэй хамтран бодлого төлөвлөлт, стратегийн арга хэмжээний зөвлөлдөх уулзалтуудыг үе шаттай зохион байгуулан ажилласан.<br>- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга болон холбогдох албан тушаалтнуудтай ҮБСОСҮХ-ны ажлын алба, ХББОСЯ, Эдийн засгийн хөгжлийн төв болон нийслэлийн албан хаагчдын хамт уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар ипотекийн хөтөлбөр, дэд бүтцийн санхүүжилтийг нэмэгдүүлэх арга замын талаар санал солилцсон.<br>- ҮБСОСҮХ-н дэд дарга Л.Энх-Амгалан, ХББОСЯ-ны сайд Ж.Батсуурь, Монгол банкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Эдийн засгийн хөгжлийн төвийн Д.Зоригт нар ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг зорилтот бүлэгт чиглүүлэх, хүүг шатлах, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүсчлэх боломжуудын талаар санал солилцсон. Уулзалтаас Монголбанк ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг шинэчлэх, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж танилцуулахаар тохиролцсон.<br>- Ипотекийн зээлийн бүсчлэл, хүүгийн шатлалын бодлогын талаар 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр ХББОСЯ, ГБХНХЯ, Монгол банк, Эдийн засгийн хөгжлийн төв, НХБХСГ, НОСБГ, НОСК зэрэг холбогдох байгууллагуудтай зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав.<br>- Ипотекийн зээлийн бүтээгдэхүүнд нэн тэргүүнд хамрагдах зорилтот бүлгийг тодорхойлох судалгаа ХХҮЕГ-ын өрхийн мэдээллийн сангийн 2023 оны мэдээлэлд үндэслэн хийсэн.<br>- Эдийн засаг хөгжлийн төвтэй хамтран Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана, Узбекистан улсын Ташкент хотуудын дахин төлөвлөлт, орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, түүний онцлог, алдаа, онооноос туршлага судлах зорилготой томилолтыг 2025 оны 2 дугаар сарын 20-27-ны өдрүүдэд зохион байгуулав.<br>- Зээлийн батлан даалтын сангийн зүгээс залуу гэр бүлийн орон сууц худалдан авах боломжийг дэмжихэд чиглэсэн шинэ нөхцөл, боломжийг судлан, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн батлан даалтын хөтөлбөрийг сайжруулах санал боловсруулахаар ажиллаж байна.<br>- Залуу гэр бүлийн орлогод нийцсэн анх удаа орон сууц худалдан авах урьдчилгаа төлбөр болон орон сууцны төрөл, байршлыг харгалзан зээлийн хүүгийн уян хатан нөхцөл бүхий ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн гаргах асуудлыг судалж байна. | | |
| 3. | Арга хэмжээ 2.3.Хуримтлалын нэгдсэн сангийн мэдээллийн нэгдсэн санг шинээр нэвтрүүлэх ажлыг үе шаттай авч хэрэгжүүлнэ. | Бэлтгэсэн мэдээллийн тоо | Одоогоор мэдээллийн сан бүрдээгүй байна. | 1 | Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 224 дүгээр тогтоолоор Хуримтлалын сангийн үйл ажиллагаанд шаардлагатай программ хангамж хөгжүүлэлтийг Санхүүгийн мэдээллийн технологийн төв Улсын төсөвт үйлдвэрийн газар хариуцан ажиллахаар зохицуулсан. Энэхүү ажлын хүрээнд тус яам Санхүүгийн мэдээллийн технологийн төв Улсын төсөвт үйлдвэрийн газартай “Хамтран ажиллах гэрээ” болон “Системийн хөгжүүлэлт, тасралтгүй ажиллагааг хангах гэрээ”-г байгуулахаар ажиллаж байна.<br>Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/158 дугаар тушаалаар батлагдсан хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн сангийн программын бодлогын даалгаврыг боловсруулахад зөвлөх үйлчилгээ | 2025.01.01-2025.06.30 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлэх бодлогын зөвлөхийг сонгон шалгаруулсан. Мөн хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн системийн программын бодлогын даалгаврыг боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх бодлогын зөвлөхтэй гэрээ байгуулан ажиллаж байна. | | |
| 4. | Арга хэмжээ 2.4.Удирдлагууд болон холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ. | Арга хэмжээний тоо | - | 30 | Удирдлагууд болон холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллаж байна.<br>- Ипотекийн зээлийн хэрэгжилт, иргэдийн орлоготой уялдуулах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол банк, ХББОСЯ, Эдийн засаг хөгжлийн төвтэй хамтран бодлого төлөвлөлт, стратегийн арга хэмжээний зөвлөлдөх уулзалтуудыг үе шаттай зохион байгуулан ажилласан.<br>- Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудтай ҮБСОСҮХ-ны ажлын алба, ХББОСЯ, Эдийн засгийн хөгжлийн төв болон нийслэлийн албан хаагчдын хамт уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар ипотекийн хөтөлбөр, дэд бүтцийн санхүүжилтийг нэмэгдүүлэх арга замын талаар санал солилцсон.<br>- ҮБСОСҮХ-ны ажлын албатай хамтран ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг зорилтот бүлэгт чиглүүлэх, хүүг шатлах, бүсчлэх боломжуудын | 2025.01.01-2025.06.30 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талаар санал солилцсон. Уулзалтаас Монголбанк ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг шинэчлэх, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж танилцуулахад ажилласан.<br>- Ипотекийн зээлийн бүсчлэл, хүүгийн шатлалын бодлогын талаар 01 дүгээр сарын 07-ны өдөр ХББОСЯ, Монгол банк, Эдийн засгийн хөгжлийн төв, НХБХСГ, НОСБГ, НОСК зэрэг холбогдох байгууллагуудтай зөвлөлдөх уулзалтад оролцсо<br>- Ипотекийн зээлийн бүтээгдэхүүнд нэн тэргүүнд хамрагдах зорилтот бүлгийг тодорхойлох судалгаа ХХҮЕГ-ын өрхийн мэдээллийн сангийн 2023 оны мэдээлэлд үндэслэн хийсэн.<br>- Эдийн засаг хөгжлийн төвтэй хамтран Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана, Узбекистан улсын Ташкент хотуудын дахин төлөвлөлт, орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, түүний онцлог, алдаа, оноонoос туршлага судлах зорилготой томилолтыг 2025 оны 2 дугаар сарын 20-27-ны өдрүүдэд зохион байгуулахад мэдээлэл бэлтгэсэн.<br>- Зээлийн батлан даалтын сангийн зүгээс залуу гэр бүлийн орон сууц худалдан авах боломжийг дэмжихэд чиглэсэн шинэ нөхцөл, боломжийг судлан, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн батлан даалтын | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөтөлбөрийг сайжруулах санал боловсруулахад ажиллаж байна.<br>- Залуу гэр бүлийн орлогод нийцсэн анх удаа орон сууц худалдан авах урьдчилгаа төлбөр болон орон сууцны төрөл, байршлыг харгалзан зээлийн хүүгийн уян хатан нөхцөл бүхий ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн гаргах асуудлыг судалж байна. | | |
| **Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1.Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | Боловсруулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг тайлагнаж дүгнүүлсэн. | 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэлтсийн даргаар батлуулсан. | 2025.01.01-2025.06.30 | 100% |
| 2. | Арга хэмжээ 3.2.Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлсэн. | - | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлсэн. | 2025.01.01-2025.06.30 | 100% |
| 3. | Арга хэмжээ 3.3.Дээд газар, холбогдох байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн | Тогтоол, шийдвэрийн тоо | Ирсэн албан бичиг, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангаН | 2 | Ирсэн албан бичиг, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангаН ажиллаж байна. | 2025.01.01-2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | биелэлтийг хангаж ажиллах; | | ажиллаж байна. | | | | |

Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.Үндэсний баялгийн сан, Хуримтлалын сантай холбоотой хууль, тогтоомжийг судлах, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх; | Холбогдох баримт бичиг, судалгаа, тайлан судалсан эсэх (Тийм:1 / Үгүй:0) | Холбогдох баримт бичиг, судалгаа, тайланг тухай бүр судалсан | 1 | Үндэсний баялгийн сан, Хуримтлалын сантай холбоотой хууль, тогтоомжийг судлан, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж ажиллаж байна. | 2025.01.01-2025.06.30 | 100% |
| 2. | Арга хэмжээ 2.Бусад цаг үеийн сургалтад хамрагдан ур чадвараа дээшлүүлэх; | Хамрагдсан сургалтын тоо | - | - | Удирдлагын академийн Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдсан. Мөн цаг үеийн сургалт, мэдээллийн цагт тогтмол хамрагдсан. 2025.06.09-2025.06.27-ны өдрүүдэд Энэтхэг Улсын Засгийн газрын тэтгэлгээр Хүний нөөцийн хөгжүүлэлтийн сургалтад хамрагдаж байна. | 2025.01.01-2025.06.30 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын — Ж.Цогзолмаа / Ж. Цогзолмаа ........................................

| | | |
|---|---|---|
| Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн хуримтлалын нэгдсэн сангийн бодлого, хууль тогтоомж хариуцсан шинжээч<br>*( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХУРИМТЛАЛЫН САНГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН ХЭЛТСИЙН ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ЖАМБАЛЖАВЫН ЦОГЗОЛМААГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтэс

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд Гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. "ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн хүрээнд Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний талаар холбогдох шийдвэрийг гаргах; | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 1.2.Хуримтлалын сангийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Арга хэмжээ 1.3.Хуримтлалын сангийн сангийн үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гаргаж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; | 42 | 7 | 49 | 49 |
| 4. | Арга хэмжээ 1.4.Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашиг болон бусад нэмэлт орлогоо Хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулахаар хүсэлт гаргасан иргэдийн мөнгөн хөрөнгийг Хуримтлалын сангийн дансанд шилжүүлэхтэй холбогдох шийдвэрийг гаргах; | 60 | 10 | 70 | 70 |
| 5. | Арга хэмжээ 1.5.Хуримтлалын сангийн талаарх олон улсын туршлага, хууль эрх зүйн орчин, холбогдох тайлан, мэдээ, дүн шинжилгээ, үндэсний болон олон улсын байгууллагын судалгаа, статистик, тоон мэдээллийг судлах, санал боловсруулах; | 60 | 10 | 70 | 70 |
| 6. | Арга хэмжээ 1.6.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Хуримтлалын санг орон сууцны санхүүжилттэй урт хугацаанд уялдуулах ажлын хүрээнд орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах зорилтот бүлгийг тодорхойлсон судалгаа хийнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| **Зорилт 2.** "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД" | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор иргэд, олон нийтэд сурталчлан таниулна. | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 2.2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана. | 60 | 10 | 70 | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 2.3.Хуримтлалын нэгдсэн сангийн мэдээллийн нэгдсэн санг шинээр нэвтрүүлэх ажлыг үе шаттай авч хэрэгжүүлнэ. | 42 | 7 | 49 | 49 |
| 4. | Арга хэмжээ 2.4.Удирдлагууд болон холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| **Зорилт 3.** "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1.Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 3.2.Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлнэ. | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Арга хэмжээ 3.3.Дээд газар, холбогдох байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг хханган ажиллах; | 60 | 10 | 70 | 70 |

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэл**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1.Үндэсний баялгийн сан, Хуримтлалын сантай холбоотой хууль, тогтоомжийг судлах, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | 100 | 15 | 15 |
| 2. | Арга хэмжээ 2.Бусад цаг үеийн сургалтад хамрагдан ур чадвараа дээшлүүлэх; | 100 | 15 | 15 |
| | **Дундаж оноо** | | 15 | 15 |

3. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, |
|---|---|---|---|

| | | | дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 7 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | 7 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | 7 |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | 7 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | 7 |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | 7 |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | 7 | 7 |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | 7 | 7 |
| | **Дундаж оноо** | 7 | 7 |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| | **Дундаж оноо** | 8 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 66.8 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(7 хүртэлх оноо)* 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* – |
| | **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)*) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | 96.8 |

**Үнэлгээ өгсөн:** **Нэгжийн дарга**

Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга
(албан тушаал)

.............................. (гарын үсэг)

/А.Хишигбаяр/
(албан хаагчийн нэр)

2025.06.13 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Төрийн жинхэнэ албан хаагч:**

Нийгмийн даатгал, хуримтлалын нэгдсэн

сангийн хэлтсийн Хуримтлалын нэгдсэн сангийн бодлого, хууль тогтоомж хариуцсан шинжээч

(албан тушаал) ............................... (гарын үсэг) /Ж.Цогзолмаа/ (албан хаагчийн нэр)

2025.06.13..........
(огноо)

**Үнэлгээг хянасан:** **Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:**

.......................................... /................................/ (албан тушаал)

............................... (гарын үсэг) В.Түвшинтогтох (албан хаагчийн нэр)

2025.06.20......
(огноо)

**Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:**

.......................................... /................................/ (албан тушаал)

............................... (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

.......
(огноо)

**Үнэлгээг баталгаажуулсан:** **Төсвийн шууд захирагч**

Төрийн нарийн
Бичгийн дарга

(албан тушаал) ............................... (гарын үсэг) /Л.Мөнхзул/ (албан хаагчийн нэр)

2025.06.20.......
(огноо)

ATA12944 9132155 9024070603